



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/175

Сүхбаатар сум

Татвар төлөгчийн өдрүүд арга хэмжээ зохион байгуулж, хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 "е", Татварын Ерөнхий хуулийн 22¹ дүгээр зүйлийн 22¹.1.1, 71 дүгээр зүйлийн 71.9.1, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.2 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жил бүрийн 5 дугаар сард улсын хэмжээнд уламжлал болсон "Татвар төлөгчдийн өдрүүд"-ийг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Татвар төлөгчдийн өдрүүд арга хэмжээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тус арга хэмжээнд шаардагдах зардал 3'199'000 /гурван сая нэг зуун ерэн есэн мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Мэнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

4. Татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд зохион байгуулагдсан арга хэмжээний болон зардлын тайланг 2019 оны 05 сарын 20-ны дотор аймгийн Засаг даргын тамгын газарт ирүүлэхийг Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Батболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 14-ний
өдрийн А/175 захирамжийн нэгдүгээр хавсралт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР, ЦАГААНУУР СУМАНД "ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДӨР" - ИЙГ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ АЖЛЫН ТӨСӨВ

МНӨА0005 9055053

2019.04.30

/ төгрөг /

Д/Д	Зардлын зүйл	Төсөв			
		Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	
3	Аймгийн Засаг дарга, Татварын хэлтсийн даргын ӨРГӨМЖЛӨЛ / бичвэр, жааз /	12	15,000	180,000	
4	Аймгийн Засаг дарга, Татварын хэлтсийн даргын ТАЛАРХАЛ / бичвэр, жааз /	70	5,000	350,000	
5	Зохион бичлэгийн уралдааний шагнал	1-р байр	1	100,000	100,000
		2-р байр	1	80,000	80,000
		3-р байр	1	50,000	50,000
		Тусгай байр	1	30,000	30,000
6	Гар зургийн уралдааний шагнал	1-р байр	1	100,000	100,000
		2-р байр	1	80,000	80,000
		3-р байр	1	50,000	50,000
		Тусгай байр	1	30,000	30,000
7	Шатрын тэмцээний шагнал	1-р байр	1	30,000	30,000
		2-р байр	1	20,000	20,000
8	Гар бөмбөгийн тэмцээний шагнал	1-р байр	1	50,000	50,000
		2-р байр	1	35,000	35,000
9	Өргөмжлөлийн цаас	50	200	10,000	
10	Гарын авлага 2019 хуанли	100	2,500	250,000	
11	Сүхбаатар, Мандал, Сайхан сумын ТВ-д ярилцлага өгөх, сурталчилгаа түгээх 3 өдрийн давтамжтай сум тус бүрт 2 телевиз	4	150,000	600,000	
12	Нэвтрүүлэг, Оройны мэдээ	1	300,000	300,000	
13	Хулдаасан хэвлэл /3x2.5 харьцаатай /	2	57,000	114,000	
14	Сэлэнгийн мэдээ сонинд мэдээлэл байршуулж тараах. Сонингийн эхний нүүрийг бүтэн авах	500	1,000	500,000	
15	Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг суманд ажиллах шатахууны зардал	420 км	2,300	120,000	
16	ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд Асуулт хариултын тэмцээн зохион байгуулж зөв хариулт тухай бүрт хүүхэд нэг бүрийг урамшуулах	120	1,000	120,000	
НИЙТ ДҮН				3,199,000	

Төсөв боловсруулсан: ТТХТ

ТУАБ Д.Тайван